



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/408

Мөрөн сум

Ахмадын асрамжийн байнгын
үйлчилгээнд хамруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.2, 19.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Орхон аймгийн Засаг дарга М.Түмэнжаргалын хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд Орхон аймгийн Баян-Өндөр сумын Цагаанчулуут багийн иргэн Зэстийн Сүхбаатар (Т369022118) нь төрөл садан нь харж хандах боломжгүй, ганц бие, байнгын асаргаанд байх шаардлагатай, хөдөлмөрийн чадвар алдалт 60 хувьтай иргэн тул Ахмад настны асрамж үйлчилгээний төвд 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн байнгын асрамжийн үйлчилгээнд хамруулахыг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн дарга (Ч.Энхбат)-д зөвшөөрсүгэй.

2. Тухайн иргэнийг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвд хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулахыг Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Х.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712011229